

МОНГОЛ-ТУВАГИЙН ХИЛИЙН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН

“Монгол Улсын Үндсэн хууль”, “Монгол Улсын хилийн тухай хууль”, “Батлан хамгаалахын цагаан ном”, “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” зэрэг баримт бичгүүдэд улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын нэг тулгуур хүчин зүйл болохыг заасан байдаг. Төр засаг, Хилийн цэргийг удирдах газрын холбогдох алба, тодорхой албаны тушаалтнууд энэхүү заалтын хэрэгжилтийн өнөөгийн дүр төрх, хилийн зөрчлийн шалтгааныг шинжлэх ухааны үндэслэлтэй нээн илрүүлж, урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулж, зохих ёсоор судалсаар иржээ. Энэхүү судалгааны баримт сэлт, илтгэл материалтай танилцахад дан ганц хилийн анги, салбаруудаас ирсэн мэдээ, баримтад тулгуурлан хилийн зөрчил, түүний шалтгааныг тайлбарласан нь учир дутагдалтай байна. Иймээс Монголын Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөл, Хилийн цэргийг удирдах газрын өмнө судлаачдын баг бүрдүүлэн улсын хилийн халдашгүй дархан байдал, хилийн зөрчлийн шалтгааныг шинжлэх ухааны үндэслэлтэй нээн илрүүлж, урьдчилан сэргийлэх арга замыг боловсруулах шаардлага зүй ёсоор тулгараад байна.

Энэхүү шаардлагад үндэслэн Монгол-Тувагийн хилийн зөрчил, түүний шалтгааныг социологийн шинжлэх ухааны онол, арга зүйн үүднээс судлахыг зорилоо. Хилийн зөрчил нь хил судлалын шинжлэх ухааны судлах зүйл болохынхоо хувьд судлаачдын анхаарлыг зайлшгүй татаж байгаа юм.

Иймд ШУТИС-ийн Хүмүүнлэгийн ухааны сургуулийн “Диагноз” судалгааны төвөөс “Монгол-Тувагийн хилийн зөрчил, түүний шалтгаан” сэдэвт судалгааг 2001 оны 10 дугаар сард явууллаа. Энэхүү судалгаанд нийт 60 хүн хамрагдсан бөгөөд тэдгээрийн 25.0 хувь нь Хилийн цэргийг удирдах газарт, 33.3 хувь нь Батлан хамгаалах салбарт, 25.0 хувь нь Тагнуулын ерөнхий газарт, 16.7 хувь нь төрийн байгууллагад тус тус ажил эрхэлдэг байхаар түүвэрлэн авсан. Судалгаанд хил хамгаалалтын өнөөгийн дүр төрх, хилийн зөрчлийн шалтгааныг зохих ёсоор үнэлж, мэдэхүйц экспертүүд хамрагдсан нь энэхүү судалгааны үнэн бодитой байдлыг хангах нөхцөл болсон юм.

Уг судалгааны мэдээллийг стандартчилсан сурвалжлагын аргаар цуглуулсан бөгөөд мэдээллийг SPSS-9.0 программ дээр боловсруулалт хийж, 3 хүчин зүйлийн хамаарлыг тооцсон болно.

Судалгаанд хамрагдагсдын 51.7 хувь нь Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдал дунд зэрэг хангагдаж байна гэж үзсэн байхад

ХИЛ СУДЛАЛ

23.3 хувь нь муу гэж үнэлжээ. Эндээс үзэхэд 75.0 дунд зэрэг буюу муу гэж үнэлсэн.

Энэхүү үнэлэмжийг судалгаанд хамрагдсагдын нас, ажил мэргэжилтэй нь харьцуулан үзэхэд ХЦУГ-т ажилладаг 20-37 насны залуучууд хилийн халдашгүй дархан байдал дунд зэрэг (100 хувь), 38-45 насныхан сайн (62.5), 46-60 насныхан сайн (83.3) хангагдаж байна гэж үнэлжээ. Эндээс БХЯ, ХЦУГ-ын ахмадууд яагаад хилийн дархан байдлыг сайн гэж үнэлсэн байна вэ? гэсэн асуулт зүй ёсоор тулгарч байна. Харин Тагнуулын ерөнхий газрын ажилтнуудын 66.7-100.0 хувь нь хилийн халдашгүй дархан байдал дунд зэрэг хангагдаж байна гэж үнэлжээ. (үг үнэмлэмжийг 1 дүгээр хүснэгтээс үзнэ үү)

Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдал

Хүснэгт №1

Нас	Ажил эрхлэлт	Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдал				Нийт
		Сайн	Дунд	Муу	Мэдэхгүй	
20-37	ХЦУГ	0.0	100.0	0.0	0.0	100.0
	БХЯ	0.0	66.7	33.3	0.0	100.0
	ТЕГ	0.0	57.1	14.3	28.6	100.0
	Төрийн байгууллага	0.0	50.0	50.0	0.0	100.0
	Нийт		61.1	27.8	11.1	100.0
38-45	ХЦУГ	62.5	37.5	0.0	0.0	100.0
	БХЯ	28.6	28.6	28.6	14.3	100.0
	ТЕГ	0.0	80.0	20.0	0.0	100.0
	Төрийн байгууллага	0.0	100.0	0.0	0.0	100.0
	Нийт	31.8	50.0	13.6	4.5	100.0
46-60	ХЦУГ	83.3	16.7	0.0	0.0	100.0
	БХЯ	0.0	66.7	33.3	0.0	100.0
	ТЕГ	0.0	100.0	0.0	0.0	100.0
	Төрийн байгууллага	0.0	0.0	100.0	0.0	100.0
	Нийт	27.8	44.4	27.8	0.0	100.0
61-	ХЦУГ	0.0	0.0	0.0	0.0	0.0
	БХЯ	0.0	0.0	100.0	0.0	100.0
	ТЕГ	0.0	0.0	0.0	0.0	100.0
	Төрийн байгууллага	0.0	50.0	50.0	0.0	100.0
	Нийт	0.0	50.0	50.0	0.0	100.0

Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдал дунд зэрэг буюу муу хангагдаж байгаа нь дараах шалтгаантай аж. Үүнд:

-Хил хамгаалалтын техник хэрэгсэл (инженерийн болон холбооны хангалтгүй байгаагаас) -33.3 хувь;

-Хил орчмын иргэдийн эдийн засгийн байдал хүндэрснээс үүдсэн наймааны сонирхол өссөнөөс (малын хулгай)-18.3 хувь;

-Олон улсын гэрээ, хэлэлцээрийн биелэлтийн хяналт сул байгаагаас -16.6 хувь ;

-Хилчдийн хариуцлага, сахилга суларч, авилгалд өртдөг болсноос-11.6 хувь ;

-Хил хамгаалалтын талаар явуулж буй төрийн бодлого тодорхойгүй байгаагаас-11.6 хувь;

-Хилийн цэрэг бие даасан бүтэцгүй, бие бүрэлдэхүүний тоо цөөнөөс-6.6 хувь ;

-Хилийн цэргийн хороо, сумангуудын тоог нэмж, зөв байршуулахгүйгээс-3.3 хувь ;

-Малын хулгай даамжирснаас -3.3 хувь;

-Хилийн шугамын явалтыг олон улсын хэмжээнд батлаагүйгээс зэрэг багтана.

Сүүлийн үед Монгол-Тувагийн хилийн зөрчлийн асуудал олны анхаарлыг татах болсонтой холбоотойгоор энэ асуудалд хүмүүсийн сэтгэл хэр зовж байгааг харьцуулан судалж, 2 дугаар хүснэгтээр үзүүлэв.

Монгол-Тувагийн хилийн зөрчил таны сэтгэлийг хэр зовоож байна вэ?

Хүснэгт №2

Нас	Ажил эрхлэлт	Монгол-Тувагийн хилийн зөрчил таны сэтгэлийг хэр зовоож байна вэ?				Нийт
		Маш их	Хилийн зөрчил гарч л байдаг тул сэтгэл тийм ч их зовохгүй байна	Бага зэрэг	Мэдэхгүй	
20-37	ХЦУГ	100.0	0.0	0.0	0.0	100.0
	БХЯ	33.2	16.7	50.0	0.0	100.0
	ТЕГ	14.3	28.6	42.9	14.3	100.0
	Төрийн байгууллага	100.0	0.0	0.0	0.0	100.0
	Нийт	44.4	16.7	33.3	5.6	100.0
38-45	ХЦУГ	75.0	12.5	12.5	0.0	100.0
	БХЯ	71.4	0.0	14.3	14.3	100.0
	ТЕГ	60.0	0.0	40.0	0.0	100.0
	Төрийн байгууллага	100.0	0.0	0.0	0.0	100.0
	Нийт	72.7	4.5	18.2	4.5	100.0
46-60	ХЦУГ	16.7	16.7	66.7	0.0	100.0
	БХЯ	50.0	16.7	33.3	0.0	100.0
	ТЕГ	33.3	0.0	33.3	33.3	100.0
	Төрийн байгууллага	66.7	33.3	0.0	0.0	100.0
	Нийт	38.9	16.7	38.9	5.6	100.0
61+	ХЦУГ	0.0	0.0	0.0	0.0	0.0
	БХЯ	100.0	0.0	100.0	0.0	100.0
	ТЕГ	0.0	0.0	0.0	0.0	0.0
	Төрийн байгууллага	100.0	50.0	50.0	0.0	100.0
	Нийт	0.0	50.0	50.0	0.0	100.0

Хоёрдугаар хүснэгтээс ерөнхийлөн харахад судалгаанд хамрагдагсдын дийлэнх олонх нь хилийн зөрчил гарч байгаад илүү сэтгэл зовж байдаг байна. Харин Тагнуулын ерөнхий газарт ажилладаг 46-60 насныханы

ХИЛ СУДЛАЛ

33.3 хувь нь энэ асуултанд хариулахаас татгалзсан байна. Тухайлбал: Судалгаанд хамрагдсан 38-45 насныхан маш их сэтгэл зовж байна. (72.7 хувь) гэж хариулсны 75.0 хувь нь ХЦУГ-т ажиллагсад байсан. Эндээс ХЦУГ-т ажиллагсад Тува-Монголын хилийн зөрчлийн асуудалд ихээхэн анхаардаг болох нь харагдаж байна.

Монгол-Тувагийн хилийн зөрчлийг сүүлийн 3 жилийн байдлаар авч үзвэл 180-210 орчимд хэлбэлзэж байгаа бөгөөд 2001 оны байдлаар хил зөрчигчдийн эсрэг хилчид 10 удаа зэвсэг хэрэглэсэн байна. Эндээс монгол-Тувагийн хилийн зөрчил нь монгол Улсын Үндэсний аюулгүй айдальд ямар хор учруулж боолхыг судалж үзэхэд экспертүүд дараах хор учирч болзошгүй гэжээ. Үүнд:

-Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдал алдагдах-33.3 хувь;

-Гадаадын иргэд, байгууллагад Монголын газар нутаг, байгалийн баялаг, түүхий эд, бүтээгдэхүүнийг хууль бусаар ашиглах сонирхол өссөн-63.3 хувь ;

-Хил, хязгаар нутагт оршин сууж буй ард түмний аж төрөх амгалан байдлыг алдагдуулах -83.3 хувь ;

-Цэрэг, улс төрийн байдал хурцдаж, зэвсэгт мөргөлдөөний байдалд хүргэх-15.0 хувь зэргийг багтааж үзжээ.

Монгол-Тувагийн хилийн зөрчил, түүний шалтгааныг экспертүүдийн санаа бодолд тулгаарлан судлахад 55.0 хувь нь хүн ам зүйн байршил нь төв хэсэгтээ төвлөрч, хил хязгаар нутаг эзэнгүйдснээс, 53.3 хувь нь эдийн засгийн сонирхлоос (малын хулгай), 48.3 хувь нь Монгол улсын талаас хөрш улсын алинд ч үзүүлэх нөлөө харьцангуй бага байгаагаас хилийн зөрчил гарч байна гэж үнэлжээ.

Мөн Монгол-Тувагийн хилийн зөрчилд аль тал нь илүү буруутай вэ? гэсэн асуултад судалгаанд хамрагдагсдын 70.0 хувь нь аль аль нь, 23.3 хувь нь Тувагийн тал, 1.7 хувь нь Монголын тал буруутай гэж тус тус хариулжээ.

ОХУ болон Хятадын хил хамгаалалтын бодлогыг судлан үзэхэд улсын хил хязгаар нутгаа эзэмших нийгэм, эдийн засгийн идэвхтэй бодлого баримтлахын сацуу хүн амын төвлөрөлтөнд ихээхэн анхаарлаа хандуулдаг байна. Манай улсын хувьд ийм бодлого баримталбал ямар үр дүнд хүрэх бол гэсэн асуултад экспертүүдийн 58.3 хувь нь зохих үр дүнд хүрнэ гэж үзсэн байхад 20.0 хувь нь ямар ч үр дүнд хүрэхгүй гэж үзжээ.

ДҮГНЭЛТ

“Монгол Улсын Үндсэн хууль”, “Монгол Улсын Хилийн тухай хууль”, “Батлан хамгаалахын цагаан ном”, “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” зэрэг баримт бичгүүдэд улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын нэг тулгуур хүчин зүйл юм гэсэн заалт ихээхэн зөрчигдөж байна гэсэн дүгнэлтийг энэхүү судалгааны үр дүн харуулж айна.

Энэхүү хилийн халдашгүй дархан байдал дунд зэрэг буюу муу (75.0 хувь) хангагдаж байгаа нь Тува, Монголын хил, хязгаар нутгийн ард түмний амьжиргааны түвшин доройтож, малын хулгай, эдийн засгийн чадавхна дээшлүүлэх сонирхол өссөнтэй шууд холбоотой байна. Тухайлбал: Тувагийн Кызыл, Красноярск, Абакан нэхий боловсруулах үйлдвэр (өдөрт 25000 нэхий боловсруулдаг), махны үйлдвэрүүд одоо хэр нь бүрэн хүчин чадлаараа ажиллаж байгаа нь малын хулгай газар авч байгаагийн шалтгаан байж болох юм.

Монгол-Тувагийн хилийн зөрчил нь улс төрийн шинжтэй гэж онцлон үзэхээсээ илүү гаалийн татвараас зайлсхийж, бараа, мал, амьтан, ургамал, түүний гаралтай бүтээгдэхүүнийг хил нэвтрүүлэх гэсэн сонирхол, Монгол Улсын талаас хөрш улсын алинд нь ч үзүүлэх улс төр, эдийн засгийн нөлөө харьцангуй бага байгаа, хил хамгаалалтын нэгдмэл бодлого алдагдсанаас үүдсэн бүс нутгийн шинжтэй зөрчил юм гэж үзэж болохоор байна. Тухайлбал судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь Тува-Монголын хилийн зөрчил нь хил хязгаар нутагт оршин сууж буй ард түмний аж төрөх амгалан байдлыг алдагдуулах /83.3 хувь/ аюултай гэсэн саналыг өгчээ.

Монгол-Тувагийн хилийн зөрчлийг багасгах талаар дараахь арга замыг судалгаанд оролцогсдын санал бодолд тулгуурлан дэвшүүлж байна. Үүнд:

1. Хил хамгаалалтын чадавхи буюу материаллаг ахуй орчинг бүрдүүлэх /хил болон хязгаар нутагт хүн амын суурьшлыг төвлөрүүлж, ард түмний болон хилчдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх хил хамгаалалтын инженерийн болон холбооны техник хэрэгслэлийг сайжруулах/ - 41.6 хувь;

2. Хоёр хөршийн найрсаг харилцааг өргөжүүлж, хил хамгаалалтын болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын хамтын үйл ажиллагааг сайжруулах -21.6 хувь;

ХИЛ СУДЛАЛ

3.Монгол-Тувагийн иргэдийн мал хулгайлан дамжуулдаг хуйвалдааны эздийг олж хариуцлага ногдуулах - 25.0 хувь;

4.Хил хамгаалалтын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэгдсэн төрийн бодлого боловсруулж, хил хамгаалалтын эрх зүйн орчинг бүрдүүлж, хяналт тавих -20.0 хувь;

5.Хилийн худалдааг нээлттэй болгож, хилийн хяналтыг зах зээлийн нөхцөлд зохицуулан өөрчлөх -10.0 хувь;

6.Хилийн зөрчил үүсч буй шалтгаан, нөхцлийг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох - 10.0 хувь;

7.Хил хамгаалалтын ур чадварыг хилчин бүрд эзэмшүүлэх сургалт зохион байгуулах -10.0 хувь зэрэг болно.

**МУШУТИС-ийн Хүмүүнлэгийн ухааны
сургуулийн нийгмийн халамж зүй, философийн
тэнхимийн багш Т.Оюунбилэг**